Мансууруулах бодисын гэмт хэрэг, эцэг эхийн анхаарал шаардлагатай

교육부
Солонгосын Боловсролын яам

한국교육환경보호원
Боловсролын орчныг хамгаалах төв

Өсвөр насныхан мансуурууулах бодисын гэмт хэрэгт холбогдсон жишээ бодитоор байдаг уу?



Сүүлийн 5 жилийн турш өсвөр насныханы мансуурууулах бодистой холбоотой гэмт хэргийн хандлага (19-өөс доош нас)

- Сүүлийн үед мансуурууулах бодисын гэмт хэрэгт холбогдсон өсвөр насныхны тоо эрс нэмэгдэж байна.
- Мөн эхлээд хохирогч байгаад эцэст нь хэрэгтэн болсон жишээ гарч байна.

※Эх сурвалж: Мансуурууулах бодисын гэмт хэргийн цагаан ном (Прокурорын ерөнхий газар, 2023)

Жишээ 1.

Сэтгэцэд нөлөөт эм гэдгийг нь мэдэлгүй интернэтээр худалдаж авсны дараа хэрэглэсэн өсвөр насныхан

- Эмчилгээний зорилгоор сэтгэцэд нөлөөт эмийг өөрийн биеэр заавал эмчид үзүүлсний дараа жор бичүүлж авах ёстой ба тогтоосон хэмжээг тодорхой хугацааны дотор хэрэглэх ёстой.
- Гэвч эмчилгээний зорилготой сэтгэцэд нөлөөт эм гэдгийг мэдэлгүй, интернэтэд тавигдсан зарна гэсэн зарлалыг уншаад худалдаж авч хэрэглэсэн өсвөр насныхан байна.
- Энэ мэт сэтгэцэд нөлөөт эмийн хууль бус худалдаа гэх сэжиг бүхий хэрэгт холбогдогчийн дийлэнх нь 10-аад насны өсвөр үеийнхэн гэдэг нь тодорхой болсон.

※Эх сурвалж : Олон нийтийн сүлжээ(SNS)-ээр мансууруулах төрлийн 'Эрвээхий эм(Фентермин төрлийн эм)' -ийг хууль бусаар борлуулсан 102 хүн .... бүлэг хэргийг мөрдөлтөд шилжүүлэв. Медикал төдэй (2023. 07. 29.)

Жишээ 2.

Сониуч зандаа хөтлөгдөн мансуурууулах бодис хэрэглэж, донтсон төдийгүй зарж борлуулагч болсон өсвөр насныхан

- Борлуулах сүлжээний урхинд автаж мансуурууулах бодис хэрэглэж, донтсон өсвөр насныхан эцэст нь мансуурууулах бодис зарж борлуулдаг гэмт хэрэгтэн болсон.
- Өөрийн мэдэлгүй гэмт хэрэгт хөл тавьсан өсвөр насныхан хожим гэмшин харуусавч нэгэнт эргүүлэхийн аргагүй болжээ.
- Тэднийг онц ноцтой, хүндүүлэн ял шийтгэх тухай хуулинд заасны дагуу мансуурууулах бодисын хэрэгт баривчилж, 5-7 жилийн хорих ялаар шийтгэсэн.

※Эх сурвалж: 'Сониуч зангаар эхлэж.... өөрөө худалдаж авсан төдийгүй зарж борлуулжээ. Ахлах сургуулийн сурагчидаар хүрээгээ тэлж буй мансуурууулах бодис', Сөүл сонин (2023. 05. 06.)

Жишээ 3.

Хүчтэй мансуурууулах бодисын гаралтай өвчин намдаах эмийг хууль бус жороор авч хэрэглэсэн өсвөр насныхан

- Тодорхой өвчнүүд (хавдрын эцсийн шат гэх мэт)-ийг эмчлэхийн тулд насанд хүрсэн хүн эмчид үзүүлсний дараа жороор авч болох сэтгэцэд нөлөөт эмийг хууль бусаар жор бичүүлж хэрэглэсэн өсвөр насныхан ч байна.
- Явандаа донтож мансуурсан өсвөр насныхан цэцэрлэгт хүрээлэн, үйлчилгээний газрын жорлон, бүр цаашлаад сургууль дотор мансуурууулах бодисыг тарьж хэрэглэсэн байна.
- Хэрэгт холбогдсон өсвөр насныхан бүгд「Мансуурууулах бодисыг зохицуулах тухай хууль」 зөрчсөн гэдэг ял шийтгүүлж, нэг хэсэг нь донтолтын хурц шинжийн улмаас эмчилгээ хийлгэж байна.

※Эх сурвалж: 'Эмч жороор өгсөн юм чинь яавал гэж ... Мансуурууулах бодист живсэн хүүхдүүд', Сөүл сонин (2021. 10. 31.)

Мансуурруулах бодис биш ч бай бүх төрлийн эм бэлдмэлийг интернэтээр худалдаалах нь хууль бус юм



- Ялангуяа борлуулагч нь мансуурруулах бодис гэдгийг нууж зарж байгаа тохиолдол их байгаа учир интернэтээр дамжуулж эм бэлдмэл худалдаж авахыг оролдож хэрхэвч болохгүй!
- Худалдаж авсны дараа бодитоор хэрэглээгүй байсан ч гэсэн мансуурруулах бодистой холбоотой гэмт хэрэгт шийтгэл хүлээнэ.

Мансууруулах бодис! Сониуч зан хүртэл аюултай юм

- Хоромхон зуурын сониуч зангаас болж эхлүүлсэн мансууруулах бодисын хэрэглээ нь илүү ноцтой гэмт хэрэг болж даамжирч болно.
- Мансууруулах бодис нь зөвхөн хадгалж байсан гэдгээрээ ч шийтгэл хүлээдэг бөгөөд, насанд хүрээгүй байсан ч биеэр эдлэх ял ногдуулж болно.
- Хүүхэд тань мансууруулах бодисын гэмт хэрэгт холбогдохгүй байхын тулд гэр бүлийн зүгээс ч анхаарал тавихыг хүсье.

Зөвөлгөө болон сургалтын байгууллага

Солонгосын мансууруулах бодистой тэмцэх алба: 1899-0893

•Улс даяар 13 орон нутагт хот, аймгийн салбаруудад биеэр очих, захидал, имэйл, утсаар зөвөлгөө авах боломжтой
•Эрүүл мэндийн байгууллагын эмчилгээтэй холбох

Хэвтэж эмчлүүлэх, амбултороор эмчлүүлэх болон зөвөлгөө өгөх байгууллага

Орон нутаг дахь эмчилгээ, хамгаалах байгууллага

Донтолтыг хянах цогц тусламжийн төв

Сурагчдад зориулсан мансууруулах бодисоос урьдчилан сэргийлэх сургалтын материал

Сурагчдын эрүүл мэндийн мэдээллийн төв : https://schoolhealth.kr

Мансууруулах бодистой холбоотой гэмт хэргийг мэдээллэх байгууллага

Цагдаа: 112 **Прокурор: 1301**

※Зөвөлгөө, сургалт болон эмчилгээний байгууллагаас зөвөлгөө авахад хувийн бүх мэдээллийг чанд хамгаална.
※Өөрөө төдийгүй гэр бүл, ойрын хүмүүсээрээ дамжуулан зөвөлгөө авч болно.